



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2011 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 137

Улаанбаатар хот

Г “Орд харш” ХК-ийн үнэт цаасыг Ү  
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам”-ын 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Орд харш” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 678,903 /зургаан зуун далан найман мянга есөн зуун гурав/ ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг үнэт цаасны газар /Э.Ганбат/, Хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжаас хасахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Компанийн тухай хуулийн 24.1, 54.1.1 дэх заалтын дагуу өөрийн эзэмшиж байгаа хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигч шаардах эрх үүссэн тухай болон уг эрхийг хэрэгжүүлэх журмын талаарх мэдэгдлийг энэхүү тогтоол гарсан өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэх, уг мэдээлэлд эрх үүссэн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг тусгахыг “Орд харш” ХК /Ч.Баатаржав/-д үүрэг болгосугай.

3. Хувьцаагаа компанид эргүүлэн авахыг шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байгаа хувьцаанд оногдох ногдол хувийн мөнгийг нэгж хувьцаанд 401 /дөрвөн зуун нэг/ төгрөгөөр тооцон “ҮЦТТТХТ” ХХК-нд гэрээ байгуулан төвлөрүүлж, хувьцаа эзэмшигчдийг шаардах эрхээ хэрэгжүүлэх нөхцлөөр хангахыг “Орд харш” ХК /Ч.Баатаржав/-д, “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

4. Хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшиж байгаа хувьцааг компанид эргүүлэн авах шаардлагыг гаргасан тохиолдолд зохих журмын дагуу нэгж хувьцаанд оногдох ногдол

хувийн мөнгийг хувьцаа эзэмшигчдэд шуурхай олгож ажиллахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

5. Шаардах эрхээ хэрэгжүүлээгүй хувьцаа эзэмшигч түүний дансанд байршуулсан ногдол хувийн мөнгөн хөрөнгийг авалгүйгээр хаалттай компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хэдийд ч гаргаж болохыг тэмдэглэсүгэй.

6. Ногдол хувийн мөнгөн хөрөнгийг хадгаламж дахь дансанд байршуулахдаа энэхүү тогтоолын 4-т заасан эрх тухайн дансны эзэнд үүссэн тухай тэмдэглэл хийж, харилцагч дансны хуулга авах тухай бүрт зохих тайлбарыг өгч ажиллахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

7. Энэхүү тогтоолын 4-т заасан хүсэлтийг гаргасан тохиололд компанийн эзэмшил дэх хувьцаанаас хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчид эзэмшүүлж, түүний хариуд уг хувьцаа эзэмшигчийн хадгаламжийн байгууллага дахь дансанд нь байршуулсан ногдол хувийн мөнгөн хөрөнгийг компанинд шилжүүлж ажиллахыг “Орд харш” ХК /Ч.Баатаржав/, “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

8. Энэхүү тогтоол хэлбэржиж гарснаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт тогтоолыг хүргэхийн хамт компанийн эзэмшилд шилжин бүртгэгдэх хувьцааны тооны талаар мэдэгдэж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН